

**НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН
ХОРООНЫ АЖЛЫН ДЭД ХЭСГИЙН 2015 ОНЫ 12 ДУГААР САРЫН 09-НИЙ
ӨДРИЙН ХУРАЛДААНЫ ТОЙМ**

Тус Байнгын хорооны 2015 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 15 дугаар тогтоолоор байгуулагдсан Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай болон холбогдох бусад хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий дэд ажлын хэсгийн хуралдаан 2015 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 13.30 цагт Төрийн ордны “334” тоот өрөөнд болов.

Дэд ажлын хэсгийн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, Ажлын хэсгийн ахлагч С.Одонтуяа, Улсын Их Хурлын даргын Ахлах зөвлөх, ажлын дэд хэсгийн ахлагч С.Ламбаа, Эрүүл мэнд, спортын яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Р.Оюунханд, Хавдар судлалын үндэсний төвийн ерөнхий захирал Л.Төмөрбаатар, Улсын II төв эмнэлгийн ерөнхий захирал Г.Баясгалан, Азийн хөгжлийн банкны Монгол дахь суурин төлөөлөгчийн газрын нийгмийн салбарын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Ж.Алтантуяа, Монголын өрхийн анагаах ухааны мэргэжилтнүүдийн холбооны ерөнхийлөгч С.Сонин, Монголын эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны ерөнхийлөгч Б.Мягмар, “Шинэ нийгэм-Эрүүл мэнд” төрийн бус байгууллагын тэргүүн С.Дуламсүрэн, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны Ажлын албаны зөвлөх Ж.Чимгээ, референт А.Болортуяа нар оролцлоо.

Ажлын дэд хэсгийн ахлагч С.Ламбаа хуралдааныг удирдаж, дэд ажлын хэсгийн хийх ажлын төлөвлөгөө, чиглэлийг танилцуулж, холбогдох яам, дэд ажлын хэсгийн гишүүдээс хуулийн төслийн талаар асуулт асууж, харилцан санал солилцлоо. Мөн ажлын дэд хэсгийн гишүүдэд хэрхэн ажиллах талаарх үүрэг, чиглэлийг өгөв.

Ажлын дэд хэсгийн хуралдаан 14.40 цагт өндөрлөлөө.

**Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны
Ажлын алба**